




ХАН-УУЛ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

2018/02



<http://www.ubstat.mn>



АГУУЛГА

	Хуудасны дугаар
 ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2016-2018 ОН	3
 ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ	4
 ДҮҮРГИЙН ТӨСӨВ	7
 АЖ ҮЙЛДВЭР	9
 ХӨДӨӨ АЖ АХУЙ	11
 НИЙГМИЙН ДААТГАЛ	12
 НИЙГМИЙН ХАЛАМЖ	14
 ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ	15
 ЭРҮҮЛ МЭНД	15
 ГЭМТ ХЭРЭГ	17
 АМЬДАРЧ БУЙ ОРЧИН	19
ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ	20

Хүснэгт 1. Дүүргийн эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, жил бүрийн II сард


Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016	2017	2018
Суурин хүн ам, сарын эцэст	хүн	151558	159983	170340
Шинээр төрсөн хүүхэд	тоо	711	620	731
Бүртгэлтэй ажилгүй иргэд, сарын эцэст	хүн	1694	1062	662
үүнээс: эмэгтэй	хүн	819	554	374
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн	тоо	578	245	312
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	316	271	438
Хэрэглээний үнийн индексийн сарын өөрчлөлт	хувь	0.8	0.8	0.7
Валютын зах зээлийн ханш, сарын эцэст	1US\$ =₮	2036.9	2470.8	2394.2
Дүүргийн төсвийн орлого	тэрбум төгрөг	9324.6	10245.1	12324.7
Дүүргийн төсвийн зарлага	тэрбум төгрөг	7029.9	7113.0	9631.9



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2018 оны 2-р сарын хэрэглээний үнийн индекс 2017 оны эцэстэй харьцуулахад 2.4 хувиар, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.1 хувиар, өмнөх 1-р сартай харьцуулахад 0.7 хувиар тус тус өссөн байна.

Зураг 1. Хэрэглээний үнийн индекс



Хэрэглээний үнийн индекс 2018 оны 2-р сард өмнөх оны эцэстэй харьцуулахад 2.4 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 4.7 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 5.8 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ 5.8 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 1.6 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ 1.6 хувь, тээврийн үйлчилгээ 2.1 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 0.7 хувь, бусад бараа, үйлчилгээний үнэ, тариф 0.7 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.

Хүснэгт 2. Хэрэглээний үнийн индекс, барааны бүлгээр

Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	<u>2017-II</u> 2016-II	<u>2018-II</u> 2017-II	<u>2018-II</u> 2017-XII	<u>2018-II</u> 2018-I
Ерөнхий индекс	101.4	108.1	102.4	100.7
Хүнсний бараа, ундаа, ус	100.9	106.7	104.7	103.4
Согтууруулах ундаа, тамхи	104.5	109.8	105.8	100.6
Хувцас, бөс бараа, гутал	98.3	105.2	98.3	98.0
Орон сууц, ус, цахилгаан, түлш	103.5	116.3	105.8	99.9
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	100.8	106.7	101.6	100.4
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	105.7	112.2	101.6	100.2
Тээвэр	100.6	111.3	102.1	100.2
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.8	100.1	99.9	99.9
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	98.4	103.9	99.6	99.9
Боловсролын үйлчилгээ	102.6	107.5	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	100.3	103.3	100.7	100.7
Бусад бараа, үйлчилгээ	102.8	108.3	100.7	99.8

2018 оны 2-р сард үнийн ажиглалт хийхээр хэрэглээний сагсанд сонгогдсон 344 нэрийн бараа, үйлчилгээний 21.5 хувийнх нь үнэ өсч, 16.9 хувийнх нь үнэ буурч, 61.6 хувийн бараа үйлчилгээний үнэ өмнөх сартай харьцуулахад тогтвортой байлаа.

Хүснэгт 3. Улаанбаатар хотын хэрэглээний үнийн сарын индекс

Бараа, үйлчилгээний бүлэг	Үнийн өөрчлөлт %	Дэд бүлэг, зарим барааны үнийн өөрчлөлт
Хүнсний бараа, ундаа, ус	3.4	Энэ бүлгийн өсөлтөд мах, махан бүтээгдэхүүн 8.3 хувиар, сүү, сүүн бүтээгдэхүүн 5.4 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.
Согтууруулах ундаа, тамхи	0.6	Энэ бүлгийн өсөлтөд архи, спирт 2.2 хувиар, шар айраг 0.6 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.
Хувцас, бөс бараа, гутал	-2.0	Хувцас, бөс бараа, гутлын бүлгийн бууралтад бүх төрлийн гутал 3.7 хувиар, бүх төрлийн хувцас 1.3 хувиар буурсан нь нөлөөлсөн байна.
Орон сууц, ус, цахилгаан, түлш	-0.1	Энэ бүлгийн бууралтад сууц хөлслөгчийн төлсөн бодит түрээс 0.3 хувиар буурсан нь нөлөөлжээ.
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	0.4	Гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн өсөлтөд хивс болон шалны бусад дэвсгэр 2.6 хувиар, гэр ахуйн удаан эдэлгээт цахилгаан болон бусад бараа 0.1 хувиар, гэр ахуйн бараа 0.9 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	0.2	Эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн өсөлт нь амбулаторийн үйлчилгээ 10.0 хувиар өссөнтэй холбоотой байна.
Тээвэр	0.2	Тээврийн үйлчилгээний бүлгийн өсөлт нь тээврийн хэрэгслийн шатах, тослох материал 0.6 хувиар өссөнөөс шалтгаалсан байна.
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	-0.1	Энэ бүлгийн бууралтад телефон аппарат, факсын хэрэгсэл 1.7 хувиар буурсан нь нөлөөлжээ.
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	-0.1	Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний бүлгийн бууралтад чөлөөт цагт зориулсан бусад хэрэгсэл 1.7 хувиар буурсан нь нөлөөлөв.
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	0.7	Энэ бүлгийн өсөлтөд ресторан, кафе, бусад зоогийн газрын үйлчилгээ 0.7 хувиар, гуанз, цайны газрын үйлчилгээ 0.9 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.
Бусад бараа, үйлчилгээ	-0.2	Бусад бараа, үйлчилгээний бууралт нь үсчин болон гоо сайхны үйлчилгээ 1.1 хувиар буурснаас шалтгаалсан байна.

2018 оны 2-р сарын 26-ны өдрийн үнийн ажиглалтаар Хан-Уул дүүргийн хүнсний зах, дэлгүүрүүдээр худалдаалагдаж байгаа хүнсний өргөн хэрэглээний 16 нэр төрлийн бүтээгдэхүүний дундаж үнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хонины мах 400 төгрөг, үхрийн мах 100 төгрөг, элсэн чихэр 100 төгрөг, байцаа 300 төгрөг, сонгино 1700 төгрөг, фүжи алим 400 төгрөгөөр тус тус буурч, “Алтан тариа” ХК-ийн дээд зэргийн гурил 140 төгрөг, “Алтан тариа” ХК-ийн 1-р зэргийн гурил 50 төгрөг, “Алтан тариа” ХК-ийн 2-р зэргийн гурил 130 төгрөг, төмс 300 төгрөг, лууван 100 төгрөг, манжин 600 төгрөг, цагаан будаа 500 төгрөг, “Сүү” ХК-ны цөцгийтэй тараг 600 төгрөгөөр тус тус өссөн байна. Харин задгай сүү, “Талх чихэр” ХК-ны “Атар” талхны үнэ тогтвортой байлаа.

Хүснэгт 4. Хүнсний өргөн хэрэглээний барааны дундаж үнэ*, төгрөг, жил бүрийн II сард


Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	2017.II	2018.II	$\frac{2018}{2017} \%$
Талх “Атар”, “Талх чихэр” ХК	Ширхэг	1160	1160	100.0
Хонины мах, ястай	Кг	5300	4900	92.5
Үхрийн мах, ястай	Кг	7000	6900	98.6
Гурил , дээд зэрэг, “Алтан тариа” ХК,	Кг	1310	1450	110.7
Гурил ,1-р зэрэг, “Алтан тариа” ХК,	Кг	1070	1120	104.7
Гурил, 2-р зэрэг, “Алтан тариа” ХК,	Кг	770	900	116.9
Элсэн чихэр	Кг	2300	2200	95.7
Төмс, монгол	Кг	600	900	150.0
Байцаа, монгол	Кг	1800	1500	83.3
Лууван, монгол	Кг	1200	1300	108.3
Манжин, монгол	Кг	1200	1800	150.0
Сонгино, хятад	Кг	2900	1200	41.4
Цагаан будаа	Кг	2300	2800	121.7
Алим, фүжи	Кг	3900	3500	89.7
Сүү, задгай	литр	1500	1500	100.0
Тараг, цөцгийтэй, “Сүү” ХК	литр	2160	2760	127.8

*- Худалдаа үйлчилгээний “Мөнхсүврага” төв


Зураг 2. Нэг кг махны дундаж үнэ, төгрөг



Зураг 3. Нэг кг гурилын дундаж үнэ, төгрөг



Зураг 4. Нэг кг төмс, лууван, байцааны дундаж үнэ, төгрөг



Зураг 5. Нэг кг манжин, сонгины дундаж үнэ, төгрөг



Хүснэгт 5. Нэг литр шатахууны үнэ, төгрөг


ШТС	2017.II.25					2018.II.26				
	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ
Жаст Ойл	1820						1480	1665	2010	
Петровис	1820	1480	1630	1710		2050	1480	1665	2010	
Магнай трейд	1820	1480	1630	1720		2050	1480	1665	2010	
Сод монгол	1820							1660	2010	
Шунхлай			1630	1715		2050		1665	2010	
Юнигаз					900					1200
Дундаж үнэ	1820	1480	1630	1715	900	2050	1480	1664	2010	1200



ДҮҮРГИЙН ТӨСӨВ

Дүүргийн төсвийн нийт орлого (үрсгал орлого болон тусламжийн орлого) 2018 оны эхний 2 сард 12.3 тэрбум төгрөг болж, төсвийн орлого төлөвснөөс 332.7 сая төгрөгөөр (2.8%) давж биелсэн бөгөөд орлогын бүрдэлт 2017 оноос (20.3%) өссөн байна. Төсвийн нийт орлогын 34.2 хувийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 4.7 хувийг татварын бус орлого (нийтлэг татварын бус орлого), 61.1 хувийг улсын төсөв болон орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг эзэлж байна.

Зураг 6. Төсвийн орлого, зарлага, 2017-2018 он, сая төгрөг



Татварын орлогын хэмжээ 4.2 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 686.0 сая төгрөгөөр (13.9%) тасарсан байна. Татварын бус орлого 574.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 209.2 сая төгрөгөөр (57.3%) давж биелсэн байна.

Хүснэгт 6. Дүүргийн төсвийн орлого, II сард сая.төг

	Төсвийн орлого			Үүнээс:								
	Бүгд	ТБ %	Зөрүү сая. төг	Татварын орлого			Татварын бус орлого			Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгийн орлого		
				Бүгд	ТБ %	Зөрүү сая.төг	Бүгд	ТБ %	Зөрүү сая.т	Бүгд	ТБ %	Зөрүү сая.т
Дүн	12324.7	102.7	332.7	4216	86.1	-686.0	574.6	157.3	209.2	7534.1	112.0	809.5


Орлогын албан татвар төлөвлөснөөс 3.2 сая төгрөгөөр, хөрөнгийн албан татвар төлөвлөснөөс 1.0 сая төгрөгөөр бусад татвар, төлбөр, хураамж төлөвлөснөөс 681.8 сая төгрөгөөр дутуу бүрдсэн байна.

Хүснэгт 7. Дүүргийн төсвийн орлого, II сар, сая төгрөг


Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ТБ %	Зөрүү
Нийт орлого	11992.1	12324.7	102.8	332.7
1.Татварын орлогын дүн	4902.0	4216	86.0	-686.0
Орлогын албан татвар	3380.2	3377	99.9	-3.2
Хувь хүний орлогын албан татвар	3380.2	3377	99.9	-3.2
Хөрөнгийн албан татвар	11.8	10.8	91.5	-1
Бусад татвар,төлбөр, хураамж	1510.0	828.2	54.8	-681.8
Улсын тэмдэгтийн хураамж	1160	621.6	53.6	-538.4
Ашигт малтмал ашигласны төлбөр	0	2.2	0	2.2
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	350	204.4	58.4	-145.6
2.Татварын бус орлогын дүн	365.4	574.6	157.3	209.2
Торгуулийн орлого	323	556.6	172.3	233.6
Төсөвт байгууллагын өөрийн орлого	29.4	13.2	45	-16.2
Бусад орлого	13.0	4.8	36.8	-8.21
3. Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	6724.7	7534.1	112.0	809.5
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	6691.3	7534.1	112.6	842.9
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	33.4	0	0	-33.4

2018 оны 2 сард орон нутгийн төсвөөс төсөвт байгууллагуудын төлөвлөсөн үйл ажиллагааны зардлын 9.6 тэрбум төгрөг (74.5%) зардлыг санхүүжүүлжээ. Өөрөөр хэлбэл, төсөвт байгууллагууд үйл ажиллагааны нийт зардлын 2.5 тэрбум төгрөг (20.5%) төлөвлөсөн хугацаандаа зарцуулаагүй байна.

Зураг 7. Татварын орлогын бүтэц, хувиар



Зураг 8. Татварын бус орлогын бүтэц, хувиар



Төсвийн нийт зарлагын 36.3 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, 4.3 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 2.0 хувийг татаас болон урсгал шилжүүлэг, 57.4 хувийг бараа, ажил үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

Хүснэгт 8. Дүүргийн төсвийн орлого, зарлага, II сар, сая төгрөг

	Орлого	Зарлага				Орлого, зарлагын зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү	
Дүүргийн дүн	12324.7	12119.5	9631.9	74.5	-2487.6	2692.8


Дүүргийн төсвөөс болон тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байгууллагууд тухайн сарын эхэнд 15.8 сая төгрөгийн өглөгтэй байсан бөгөөд 24.7 сая төгрөгийн өглөг шинээр үүсч, 10.8 сая төгрөгийн өглөгийг барагдуулж, сарын эцэст нийт 29.7 сая төгрөгийн өглөгтэй болсон байна.



АЖ ҮЙЛДВЭР


Дүүргийн аж үйлдвэрийн газрууд 2018 оны эхний 2 сард 159.0 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 125.0 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлт 29.1 хувиар, борлуулалт 14.5 хувиар тус тус өссөн байна.

Зураг 9. Аж үйлдвэрийн үйлдвэрлэлт, борлуулалт, 2017-2018 оны сар бүрээр, тэрбум төгрөг




Аж үйлдвэрийн нийт борлуулалтын 113.4 тэрбум төгрөгийг дотоодод, 11.6 тэрбум төгрөгийг гадаадад борлуулсан байна. Нийт борлуулсан бүтээгдэхүүний 9.3 хувийг экспортод гаргасан бөгөөд нийт экспортын 79.0 хувийг ноос, ноолуур, нэхмэлийн үйлдвэрлэлт, 17.1 хувийг арьс ширний үйлдвэрлэлт, 0.1 хувийг ундаа үйлдвэрлэлт, 1.6 хувийг мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, 2.2 хувийг ашигт малтмалын олборлолт тус тус эзэлж байна.

Зураг 10. Үйлдвэрлэлт, 2016-2018 он, тэрбум төг



Зураг 11. Борлуулалт, 2016-2018 он, тэрбум төг



Хүснэгт 9. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, салбараар, өссөн дүнгээр /оны үнээр, сая төгрөг/

Салбараар	Нийт бүтээгдэхүүн		
	2017	2018	$\frac{2018}{2017} \%$
	I-II cap	I-II cap	
Уул уурхай олборлох үйлдвэр	71.2	609.5	8.6*
Төмрийн хүдэр олборлолт	0.0	360.7	-
Бусад ашигт малтмал олборлолт	71.2	248.8	3.5*
Боловсруулах үйлдвэр	98309.3	131992.0	134.3
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	53633.9	68926.9	128.5
Мах, загас, ногоо, тос боловсруулалт	384.7	656.8	170.7
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	3006.9	7533.8	2.5*
Хүнсний бусад бүтээгдэхүүн	5711.6	5771.7	101.1
Ундаа үйлдвэрлэл	44530.7	54964.6	123.4
Нэхмэлийн үйлдвэрлэлт	29062.0	43029.6	148.1
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	389.2	1048.3	2.7*
Арьс шир боловсруулах үйлдвэр	2728.0	2867.8	105.1
Мод, модон эдлэл	1122.2	2420.9	2.1*
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1079.4	1762.7	163.3
Хэвлэл болон дуу бичлэгийн үйл ажиллагаа	599.2	1069.4	178.5
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	8084.0	9266.4	114.6
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн	1321.7	1286.6	97.3
Төмөрлөг бүс эрдэс бодисоор хийсэн эдлэл	8.3	0.0	-
Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл	21.4	30.6	143.0
Эмнэлгийн багаж хэрэгсэл үйлдвэрлэл	222.1	232.7	104.8
Мебель тавилга үйлдвэрлэл	37.9	50.1	132.2
Цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэлт	24751.4	26388.8	106.6
ДҮН	123131.9	158990.3	129.1

*-дахин

Хүснэгт 10. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний борлуулалт, салбараар, өссөн дүнгээр /оны үнээр, сая төгрөг/

Салбараар	Аж үйлдвэрийн борлуулалт			
	2017	2018	$\frac{2018}{2017}\%$	үүнээс: экспорт, %
	I-II cap	I-II cap		
Уул уурхай олборлох үйлдвэр	71.2	609.5	8.6*	0.4
Төмрийн хүдэр олборлолт	0.0	360.7	-	-
Бусад ашигт малтмал олборлолт	71.2	248.8	3.5*	100.0
Боловсруулах үйлдвэр	84314.8	97992.7	116.2	11.6
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	49235.4	51908.4	105.4	0.4
Мах, загас, ногоо, тос боловсруулалт	384.7	339.1	88.1	54.5
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	3331.6	10764.9	323.1	
Хүнсний бусад бүтээгдэхүүн	5110.5	5895.5	115.4	
Ундаа үйлдвэрлэл	40408.6	34908.9	86.4	
Нэхмэлийн үйлдвэрлэлт	20375.4	27101.8	133.0	33.7
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	362.2	842.5	2.3*	
Арьс шир боловсруулах үйлдвэр	2711.1	2865.2	105.7	69.2
Мод, модон эдлэл	1122.2	2420.9	2.1*	
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1079.4	1762.7	163.3	
Хэвлэл болон дуу бичлэгийн үйл ажиллагаа	772.2	886.6	114.8	
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	6924.9	8525.9	123.1	
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн	1321.7	1286.6	97.3	
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл	52.1	99.0	190.0	
Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл	21.4	30.6	143.0	
Эмнэлгийн багаж хэрэгсэл үйлдвэрлэл	298.9	212.4	71.1	
Мебель тавилга үйлдвэрлэл	37.9	50.1	132.2	
Цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэлт	24751.4	26388.8	106.6	
ДҮН	109137.4	124991.0	114.5	9.3

*-дахин




ХӨДӨӨ АЖ АХУЙ

Дүүргийн хэмжээнд 2018 оны эхний 2-р сард 118 толгой мал зүй бусаар хорогдсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 157 толгой малаар буурчээ. Нийт хорогдлын 19.5 хувийг бод мал, 80.5 хувийг бог малын хорогдол эзэлж байна. Мөн хорогдсон малын 38.1 хувийг хээлтэгч малын хорогдол эзэлж байна.

Хүснэгт 11. Том малын зүй бус хорогдол, жил бүрийн II сард

Үзүүлэлт	2017.II	2018.II	Үүнээс:				
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Хорогдсон том мал	275	118	-	8	15	33	62
Үүнээс: Хорогдсон хээлтэгч	8	95	-	2	3	30	60
Хорогдсон хээлтэгч	233	45	-	-	6	16	23

Зураг 12. Том малын зүй бус хорогдол, төрлөөр



НИЙГМИЙН ДААТГАЛ

2018 оны эхний 2-р сард Хан-Уул дүүргийн нийгмийн даатгалын салбарын үйлчилгээнд 2743 байгууллагын нийт 89.7 мянга гаруй хүн хамрагдаж, шимтгэл төлсөн ба тэдгээрийн 47.9 мянга (53.4%) нь ААНБ-ын, 8.7 мянга (9.8%) нь төсвийн байгууллагын, 5.9 мянга (6.6%) нь сайн дурын даатгуулагчид, 27.1 мянга (30.2%) нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан даатгуулагчид байна.

Хүснэгт 12. Нийгмийн даатгалын байгууллагаар үйлчлүүлсэн байгууллага болон даатгуулагчийн тоо

Үзүүлэлт	2017.II	2018.II	Өсөлт	
			тоо	хувь
Нийт байгууллагын тоо	2462	2743	281	111.4
Аж ахуйн нэгж байгууллагын тоо	2346	2623	277	111.8
Төсөвт байгууллагын тоо	116	120	4	103.4
Нийт даатгуулагчдын тоо	82098	89707	7609	109.3
ААНБ-ын даатгуулагчийн тоо	40833	47923	7090	117.4
Төсөвт байгууллагын даатгуулагчийн тоо	8467	8799	332	103.9
Сайн дурын даатгуулагчийн тоо	1568	5931	4363	378.3
Эрүүл мэндийн даатгуулагчийн тоо	31230	27054	-4176	86.6

2018 оны 2-р сард дүүргийн нийгмийн даатгалын сангийн нийт орлого 24.9 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 4.3 тэрбум төгрөгөөр (20.9%) давж биелсэн байна. Орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.6 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.


Хүснэгт 13. Нийгмийн даатгалын сангийн орлого, сан түс бүрээр, II сард

Үзүүлэлт	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Биелэлт %	
	2017.II	2018.II	2017.II	2018.II	2017	2018
Тэтгэврийн даатгалын сангийн орлого	9964.4	13412.5	12013.9	16852.3	120.6	125.6
Тэтгэмжийн сангийн орлого	1234.3	1505.6	1365.8	1895.2	110.7	125.9
ҮОМШӨ*-ний даатгалын орлого	1029.4	1341.7	1666.2	1750.6	161.9	130.5
Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого	270.2	307.4	320.6	382.3	118.7	124.4
Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого	3278.3	4111.9	3444.2	4111.9	105.1	100.0
Нийт	15776.6	20679.1	18810.7	24992.3	119.2	120.9


Тайлбар: ҮОМШӨ-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин

Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 67.4 хувийг тэтгэврийн даатгалын санд, 7.6 хувийг тэтгэмжийн даатгалын санд, 7.0 хувийг ҮОМШӨ-ний даатгалын санд, 1.5 хувийг ажилгүйдлийн даатгалын санд, 16.5 хувийг эрүүл мэндийн даатгалын сангийн орлого тус тус эзэлж байна.

Зураг13. Нийгмийн даатгалын сангийн орлогын бүтэц, хувиар



Зураг 14. Нийгмийн даатгалын сангийн зарлагын бүтэц, хувиар




Тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авагч 13719 хүнд 10.5 тэрбум төгрөгийг, тахир дутуугийн тэтгэвэр авагч 2994 хүнд 1.5 тэрбум төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 798 хүнд 413.1 сая төгрөгийг, цэргийн тэтгэвэр авагч 1085 хүнд 1.3 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.

Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсан 2065 хүнд 311.3 сая төгрөгийг, жирэмсэн болон амаржсан 803 хүнд 1.1 тэрбум төгрөгийг, 10 хүнд оршуулгын тэтгэмж 9 сая төгрөгийг тус тус олгожээ.

ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагч 166 хүнд 150.9 сая төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 18 хүнд 14.8 сая төгрөгийг, тэтгэмж төлбөрт 22 хүнд 14.5 сая төгрөгийг тус тус олгосон байна. Ажилгүйдлийн тэтгэмж авсан 270 хүнд 508.6 сая төгрөг зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангийн нийт зардлын 63.9 хувийг тэтгэврийн, 8.5 хувийг тэтгэмжийн, 7.9 хувийг ҮОМШӨ-ний, 2.2 хувийг ажилгүйдлийн, 17.6 хувийг эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

Зураг 15. Даатгалын сангийн орлого, зарлага сая,төг



Зураг 16. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо





НИЙГМИЙН ХАЛАМЖ

2018 оны эхний 2 сард нийгмийн халамжийн сангийн нийт орлогын 11.1 хувь нь насны хишиг тэтгэмжинд, 17.3 хувь нь цалинтай ээж хөтөлбөр, 2.4 хувь нь алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжинд тус тус хуваарилсан байна. Харин зарлагын 43.7 хувь нь нийгмийн халамжийн санд буюу нийт 11405 хүнд, 6479 хүнд насны хишиг, 6834 хүнд цалинтай ээж хөтөлбөрийн тэтгэмж, 5440 хүнд алдарт эхийн одонгийн тусламж, 278 хүнд алдар цолтой ахмадын хөнгөлөлт, тусламж, 2042 хүнд жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмжийг тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 14. Нийгмийн халамжийн сангийн үзүүлэлт, II сард, сая.төг

Үзүүлэлт	Дүн	Хүний тоо
Нийгмийн халамжийн сангийн орлого	4 865.6	
1.Нийслэлийн төсвийн санхүүжилтийн орлого	2 289.2	
а) Нийгмийн халамжийн сан	2 041.2	
б) жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж	82.0	
в) ОНОТХаламжийн үйлчилгээ	0	
г) хүнс тэжээл хөтөлбөр	166.0	
2. Улсын төсвийн санхүүжилтийн орлого	2 559.5	
а) алдарт эхийн одонгийн тусламж	1 010.0	
б) алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	115.0	
в) насны хишиг	542.5	
г) цалинтай ээж хөтөлбөр	840.0	
д)өрх толгойлсон эцэг эхэд олгох тэтгэмж	52.0	
3. Үйлчилгээний орлого	16.9	
а) хүүгийн орлого	5.4	
б) маягтын орлого		
в) бусад орлого	11.5	
Зарлагын нийт дүн	4 168.8	33 933
1. Нийгмийн халамжийн сан	1 823.6	11 405
2. Жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж	157.3	2 042
3. Алдарт эхийн одонгийн тусламж	716.1	5 440
4. Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	103.4	278
5. Хүнс тэжээл хөтөлбөр	175.4	1 381
6. ОНОТХ Үйлчилгээний зардал	10.6	34
7. Насны хишиг	540.6	6 479
8. Цалинтай ээж хөтөлбөр	632.2	6 834
9. Өрх толгойлсон эцэг эхэд олгох тэтгэмж	9.6	40



ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ


Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 2018 оны 2-р сард 662 байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 400 хүнээр буурсан байна. Нийт ажилгүйчүүдийн 56.5 хувь нь эмэгтэйчүүд байна.

Оны эхний 2 сард орон тооны цомхтголоор 34, байгууллага татан буугдсанаас 5, өөр газраас шилжиж ирсэн 13, сургууль төгссөн 9, цэргээс халагдсан 1, мэргэжлийн ажил олдохгүй 52, цалин багатайгаас 57, бусад шалтгаанаар 78 хүн ажилгүй болжээ. Тайлант сард 23 хүн ажилд орсноос улсын үйлдвэрийн газарт 1, төрийн төсөвт байгууллагад 9, нөхөрлөл компанид 13 хүн ажилд орсон байна.

Хүснэгт 15. Бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролын түвшнээр, жил бүрийн II сарын эцэст

Үзүүлэлт	Ажилгүйчүүдийн тоо			Дүнд эзлэх хувь		
	2016.II	2017.II	2018.II	2016.II	2017.II	2018.II
Нийт ажилгүйчүүд	1 694	1 062	662	100.0	100.0	100.0
Дээд боловсролтой	796	541	344	47.0	50.9	52.0
Тусгай дунд боловсролтой	108	50	34	6.4	4.7	5.1
Мэргэжлийн анхан шатны	99	40	15	5.8	3.8	2.3
Бүрэн дунд боловсролтой	638	411	247	37.7	38.7	37.3
Бүрэн бус дунд боловсролтой	36	17	13	2.1	1.6	2.0
Бага, боловсролгүй	17	3	9	1.0	0.3	1.3

Зураг 17. Ажилгүйчүүд насны бүлгээр, II сарын эцэст



Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 264 (40.0%) нь анх удаа ажил хайж байгаа бол 398 (60.0%) нь урьд ямар нэг ажил хийж байжээ.

Насны бүлгээр авч үзвэл нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 45 (6.8%) нь 16-24 насны, 270 (40.8%) нь 25-34 насны, 203 (30.7%) нь 35-44 насны, 144 (21.7%) нь 45-60 насны хүмүүс байна.



ЭРҮҮЛ МЭНД


Дүүргийн хэмжээнд 2018 оны 2 сард 312 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 67 (27.3%) хүнээр, 10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 3.4 процидмилээр нэмэгдсэн байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчдийн 30.1 хувийг салхин цэцэг, 13.8 хувийг шинээр илэрсэн сүрьеэ, 6.1 хувийг тэмбүү, 12.8 хувийг гар хөл амны өвчин, 1.6 хувийг трихомониаз, 13.5 хувийг цусан суулга, 1.6 хувийг заг хүйтэн, 2.9 хувийг вирус хепатит 17.6 хувийг бусад өвчнөөр өвчлөгчид тус тус эзэлж байна.


Хүснэгт 16. Дүүрэгт гарсан халдварт өвчин, эхний II сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017.II	2018.II	Өсөлт, бууралт 2018/2017	
				тоо/пункт	Хувь
НИЙТ ХАЛДВАРТ ӨВЧИН	Бодит тоо 10000 хүнд	245 16.2	312 19.6	67 3.4	27.3
Вируст гепатит	Бодит тоо 10000 хүнд	3 0.2	9 0.6	6 0.4	3 дах
Цусан суулга	Бодит тоо 10000 хүнд	19 1.3	42 2.6	23 1.3	2.2 дах
Улаан эсэргэнэ	Бодит тоо 10000 хүнд	14 0.9	20 1.3	6 0.4	42.8
Сальмонеллөз	Бодит тоо 10000 хүнд	2 0.1	2 0.1	- -	-
Салхин цэцэг	Бодит тоо 10000 хүнд	91 6.0	94 5.9	3 -0.1	3.3
Гахайн хавдар	Бодит тоо 10000 хүнд	5 0.3	1 0.1	-4 -0.2	-80
Ёлом	Бодит тоо 10000 хүнд	1 0.1	2 0.1	1 1.0	1 дах
Гар хөл, амны өвчин	Бодит тоо 10000 хүнд	18 1.2	40 2.5	22 1.3	2.2 дах
Тэмбүү	Бодит тоо 10000 хүнд	16 1.1	19 1.2	3 0.1	18.8
Заг хүйтэн	Бодит тоо 10000 хүнд	8 0.5	5 0.3	-3 -0.2	-37.5
Трихомониаз	Бодит тоо 10000 хүнд	17 1.1	5 0.3	-12 -0.8	-70.6
Шинээр илэрсэн сүрьеэ	Бодит тоо 10000 хүнд	30 2.0	43 2.7	13 0.7	43.3
Мөөгөнцөр	Бодит тоо 10000 хүнд	3 0.2	2 0.1	-1 -0.1	-33.3
Улаан бурхан	Бодит тоо 10000 хүнд	- -	- -	- -	-
Бусад өвчлөл	Бодит тоо 10000 хүнд	18 1.2	28 1.8	10 0.6	55.6

Зураг 18. Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд



Зураг 19. Халдварт өвчнөөр өвчлөгчид



2018 оны 2 сард төрөхийн улмаас эндсэн эх байхгүй, нялхсын эндэгдэл өмнөх оны мөн үеийн түвшинд байна. Харин 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1-ээр нэмэгджээ.

Хүснэгт 17. Төрсөн хүүхэд, эх, хүүхдийн эндэгдэл, II сард

Үзүүлэлт	2016.II	2017.II	2018.II	$\frac{2018}{2017}\%$
Амаржсан эхийн тоо	706	617	728	18.0
Амьд төрсөн хүүхэд	711	620	731	17.9
Төрөхийн улмаас эндсэн эх	-	-	-	-
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	4	10	10	-
1-5 хүртэл насандаа эндсэн хүүхэд	3	1	2	1*

Мэдээллийн эх сурвалж: Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв

*дахин



ГЭМТ ХЭРЭГ

Дүүргийн хэмжээнд 2018 оны эхний 2 сард 438 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 167 (61.6%) хэргээр өсчээ.

Зураг 20. Гэмт хэргийн тоо



Нийт гэмт хэргийн 140 (32.0%) нь хулгайн хэрэг, 125 (28.5%) нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг хэрэг, 72 (16.4%) хэрэг нь залилан мэхлэх гэмт хэрэг, 1 (0.2%) хэрэг нь олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах хэрэг, 7 (1.6%) нь хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх хэрэг, 2 (0.5%) нь хүчингийн хэрэг, 15 (3.4%) нь дээрэмдэх хэрэг, 15 (3.4%) нь ХАБТХАЖЭ хэрэг, 2 (0.5%) нь хүнийг алах хэрэг, 2 (0.5%)

нь малын хулгайн хэрэг, 57 (13.0%) нь бусад гэмт хэргүүд тус тус эзэлж байна.


Хүснэгт 18. Бүртгэгдсэн гэмт хэрэг, төрлөөр

Гэмт хэргийн төрөл	Гэмт хэргийн тоо		Өсөлт, бууралт	
	2017.II	2018.II	$\frac{2018}{2017}\%$	Тоо
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	12	7	-41.7	-5
Хүчин	2	2	0.0	0
Дээрэмдэх	0	15	-	15
Хулгай	84	140	66.7	56
Залилан мэхлэх	20	72	260.0	52
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	71	125	76.1	54
Малын хулгай	0	2	-	2
Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах	13	1	-92.3	-12
Хүнийг санаатай алах	2	2	0.0	0
ХАБТХАЖЭ	24	15	-37.5	-9
Бусад	43	57	32.6	14
Бүгд	271	438	61.6	167

*ХАБТХАЖЭ-хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг

Нийт хулгайн хэрэг 140 байгаагаас 90.0 хувь нь иргэний өмчийн хулгай, 4.3 хувь нь халаасны хулгай, 2.9 хувь нь авто тээврийн хэрэгслийн хулгайн хэрэг эзэлж байна.

Зураг 21. Бүртгэгдсэн гэмт хэрэг, хороогоор



Хүснэгт 19. Бүртгэгдсэн гэмт хэрэг, хороогоор

Хороо	Гэмт хэрэг		Өөрчлөлт		Хүнийг алах	Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	Үүнээс	Хүчин	Хулгай	Үүнээс			Дээрэмдэх	Залилан мэхлэх	Малын хулгай	Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах	ХАБТХАЖЭ	Бусад
	2017.II сар	2018.II сар	Тоо	%				Гэр бүлийн хүчирхийлэл			ИӨХ	Авто тээврийн хэрэгсэл хулгайлах	Халаасны хулгай						
1	9	21	12	133.3	0	0	3	0	0	5	5	0	0	2	4	0	0	2	5
2	30	28	-2	-6.7	0	0	5	0	1	10	5	1	2	2	8	0	0	0	2
3	40	51	11	27.5	0	0	18	0	0	8	5	2	0	2	10	0	0	4	9
4	27	36	9	33.3	1	2	7	0	0	19	19	0	0	1	1	0	0	0	5
5	6	10	4	66.7	0	0	5	0	0	1	1	0	0	1	1	0	0	1	1
6	4	15	11	275.0	1	1	5	1	0	3	3	0	0	1	3	0	0	0	1
7	1	7	6	600.0	0	0	5	1	0	0	0	0	0	1	0	0	0	0	1
8	13	22	9	69.2	0	1	10	3	0	5	5	0	0	0	4	0	0	0	2
9	7	11	4	57.1	0	0	0	0	0	8	8	0	0	1	1	0	0	0	1
10	26	41	15	57.7	0	0	9	1	0	20	19	0	0	1	6	0	0	0	5
11	31	73	42	135.5	0	1	19	1	1	24	24	0	0	1	17	0	0	2	8
12	8	17	9	112.5	0	0	8	0	0	3	3	0	0	0	1	1	0	1	3
13	6	10	4	66.7	0	0	4	1	0	3	3	0	0	0	1	1	0	1	0
14	11	12	1	9.1	0	0	3	0	0	8	8	0	0	0	1	0	0	0	0
15	43	58	15	34.9	0	2	14	1	0	16	11	1	4	1	11	0	0	2	12
16	9	26	17	188.9	0	0	10	3	0	7	7	0	0	1	3	0	1	2	2
Дүн	271	438	167	61.6	2	7	125	12	2	140	126	4	6	15	72	2	1	15	57

*ХАБТХАЖЭ-хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг



АМЬДАРЧ БУЙ ОРЧИН

Нийслэлийн агаарын дундаж хэм 2018 оны 2-р сард дунджаар -17.7°C байв. Энэ нь өмнөх оны мөн үеэс -4.0°C -аар, олон жилийн дундажтай харьцуулбал -1.0°C -аар тус тус хүйтэн байв. Энэ сарын хамгийн дулаан хэм -2.9°C , хамгийн хүйтэн хэм -28.3°C , хүр тунадасны нийлбэр 3.2 миллиметр, салхины үнэмлэхүй их хурд 17 метр секунд хүрч, цасан бүрхүүлийн зузаан 11 сантиметр, шороон болон цасан шуургатай 4 өдөр бүртгэгдсэн байна.

Хүснэгт 20. Хан-Уул дүүргийн агаар дахь бохирдуулагч бодисын хоногийн дундаж агууламж, $\text{мг}/\text{м}^3$, II-р сард

Агаарын бохирдлын үзүүлэлт		Мишээл – экспо төв			Нисэх		
		2016.II	2017.II	2018.II	2016.II	2017.II	2018.II
		$\text{Мг}/\text{м}^3$					
Хүхэрлэг хий SO_2	Дундаж	-	-		0.04	0.022	0.015
	Хамгийн их	-	-		0.195	0.041	0.023
	XXX*-с давсан хувь	-	-		29	-	-
	Хэмжилтийн тоо	-	-		7	22	21
Азотын давхар исэл NO_2	Дундаж	-	-		0.023	0.032	0.024
	Хамгийн их	-	-		0.05	0.051	0.041
	XXX*-с давсан хувь	-	-		10	9.1	-
	Хэмжилтийн тоо	-	-		10	22	28
Нүүрстөрөгчийн дутуу исэл CO	Дундаж	-	-		1.119	0.973	1.223
	Хамгийн их	-	-		2.083	2.211	3.189
	XXX*-с давсан хувь	-	-		-	-	-
	Хэмжилтийн тоо	-	-	Хэмжилт хийгдээгүй	29	70	84
Тоос PM_{10}	Дундаж	0.124	0.080		0.119	0.119	0.136
	Хамгийн их	0.399	0.134		0.174	0.202	0.274
	XXX*-с давсан хувь	54	21.4		70	63.6	71.0
	Хэмжилтийн тоо	28	28		10	22	28
Тоос PM_{25}	Дундаж	-	-		0.098	0.105	0.125
	Хамгийн их	-	-		0.124	0.175	0.262
	XXX*-с давсан хувь	-	-		100	86.4	86.0
	Хэмжилтийн тоо	-	-		10	22	28
Озон O_3	Дундаж	0.041	-		0.019	0.032	0.028
	Хамгийн их	0.064	-		0.04	0.073	0.051
	XXX*-с давсан хувь	-	-		-	-	-
	Хэмжилтийн тоо	86	-		30	70	84

*- Хүлцэх хэм хэмжээ, **- CO , O_3 -ийн хэмжилтийг 8 цагийн дунджаар тооцсон

Эх үүсвэр: “Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2017 оны II сарын танилцуулга

Туул голын усны бохирдол:

Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторийн 2018 оны 2-р сарын 08, 09-ны өдрүүдэд хийсэн хэмжилтээр Туул голын усны найрлага Туул-Налайх харуул цэгийн орчимд бохирдуулагч бодисын хэмжээ хэвийн, Туул-Сонгино доод харуул цэгийн орчимд хүчилтөрөгчийн хэмжээ горим алдагдаж бохирдолтой, амоны азот 67.7 дахин, эрдэс фосфор 30.2 дахин, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 15.5 дахин, нитридийн нэгдлийн хэмжээ 5.3 дахин хүлцэх хэм хэмжээнээс давж, Туул голын ус бохирдолтой хэвээр байна.

Хүснэгт 21. Нийслэлийн гадаргын усны найрлага, мг/м³, II-р сард¹

Үзүүлэлт		Стандарт хэмжээ	“Туул-Налайх” харуул цэг		“Туул-Сонгино доод” харуул цэг	
			Хэмжээ	Бодисын хэтрэлт	Хэмжээ	Бодисын хэтрэлт
Хүчилтөрөгч	O ₂	≥6	7.12	Хэвийн	0.05	Горим алдагдсан
Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч	BXX ₅	≤ 3	1.1	Хэвийн	46.4	15.5 дахин
Нитридийн нэгдэл	NO ₂	≤ 0.02	0.005	Хэвийн	0.105	5.3 дахин
Амоны азот	NH ₄	≤0.5	0.02	Хэвийн	33.84	67.7 дахин
Эрдэс фосфор	P	≤0.1	0.005	Хэвийн	3.018	30.2 дахин

*Эх үүсвэр: Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори

ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ

2018 оны 2-р сарын байдлаар Хан-Уул дүүргийн Засаг даргын тамгын газарт иргэдээс 512 өргөдөл, гомдол ирснээс 274-ийг нь хуулийн дагуу хугацаанд нь хариу өгч ажиллажээ. Шийдвэрлэх хугацаа болоогүй 238 өргөдөл байна.

“Хан-Уул дүүргийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2018 оны II сарын танилцуулга

Хүснэгт 22. Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ

Байгууллагын нэр	Өргөдөл гомдлын тоо	Хэлбэр				Агуулга				Бусад байгууллагад шилжүүлсэн	Хуулийн хугацаанд хариу өгсөн	Хүлээгдэж байгаа	Хугацаа болоогүй	Хугацаа хэтэрсэн
		Амаар	Бичгээр	Утсаар	Цахим сүлжээгээр	Гомдол	Санал	Мэдэгдэл	Хүсэлт					
ТЗУХ	38		32	-	6	2		-	36		38			
СТСХ	-		-	-	-	-		-	-		-			
ТГХШХ	-		-	-	-	-		-	-		-			
НХХ	18		16	-	2	8		-	10		18			
ТНААХ	31		20	9	2	13		-	18		29		2	
ХХҮХ	11		6	-	5	4		1	6		11			
Хууль зүйн тасаг	8		6	-	2	-		-	8		8			
Цэргийн штаб	2		2	-	-	-		-	2		2			
ЗДТГ-ын дүн	108		82	9	17	27		1	80		106		2	
ХөХҮХ	34		25	-	9	9		-	25		34		-	
Газрын алба	282		253	-	29	-		-	282		46		236	
БоХ	6		5	1	-	1		1	4	1	5		-	
ОБХ	-			-	-	-		-	-		-		-	
Албан бус- НТБ төв	70		70	-	-	-		-	70		70		-	
БүХ	12	11		1	-	1		-	11		12		-	
Дэргэдэх хэлтэс албадын дүн	404	11	353	2	38	11		1	392	1	167		236	

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС
Танилцуулгыг эрхлэн гаргасан: мэргэжилтэн Д.Оюунгэрэл



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Статистик

Мэдээ, мэдээлэл

Номын сан

Мэдлэгээ шалгах тоглоом

Валютын ханш



1212.mn аппликейшнаас
СТАТИСТИКИЙН
мэдээллээ аваарай



СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

2018



WWW.1212.MN

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН


Статистик

Мэдээ, мэдээлэл

Номын сан

Мэдлэгээ шалгах тоглоом

Валютын ханш



аппликейшнаас

СТАТИСТИКИЙН
мэдээллээ аваарай



Data lab

тооллого судалгааны микро мэдээллийн сан



SOCIAL NETWORK



[www.facebook.com/
StatisticMongolia/](https://www.facebook.com/StatisticMongolia/)



[www.twitter.com/
statistic_mn](https://www.twitter.com/statistic_mn)

ЛАВЛАХ УТАС



1900-1212

ЦАХИМ ШУУДАН



information@nso.mn